

Монгол Улсын Үндэсний аудитын газар

ҮАГ

Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны
хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2005 оны 11 дүгээр

сар

**ГАДААДЫН ЗЭЭЛИЙГ ДОТООДДОО
ӨНДӨР ХҮҮТЭЙ, БОГИНО
ХУГАЦААТАЙ ДАМЖУУЛАН
ЗЭЭЛДҮҮЛЖЭЭ**

**Эрчим хүчний салбарт Дэлхийн банк,
Азийн хөгжлийн банк, хандивлагч орны
зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн
шалгаруулалт, гадаад зээлийн буцаан
төлөлт**

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	2
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	2-3
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	3
Аудитын дүн	Эрчим хүчний салбарт гадаадын зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалт	4 - 5
	Эрчим хүчний салбарын гадаад зээлийн буцаан төлөлт	6 -11
	Засгийн газраас төслийн зээлийн хэрэгжилтэд тавьсан хяналт	11 - 12
Дүгнэлт		13
Холбогдох байгууллагын санал	Сангийн яамны санал	14-17
	Түлш, эрчим хүчний яамны санал	18-30
	Яамдын саналд өгөх тайлбар	31-32
Зөвлөмж		33

Товчилсон үгс:

ДБ – Дэлхийн банк
АХБ – Азийн хөгжлийн банк
ГЭЗТХАС – Гадаадтай эдийн засгийн талаар
хамтран ажиллах сан
ЯОУХАБ – Японы олон улсын хамтын
ажиллагааны банк
ТЭХЯ – Түлш, эрчим хүчний яам
ЭХУГ – Эрчим хүчний удирдах газар
ТЭХС – Төвийн эрчим хүчний систем
ДЦС-3 – Дулааны цахилгаан станц-3
ДЦС-4 – Дулааны цахилгаан станц-4
ДДЦС – Дарханы дулааны цахилгаан станц
УБЦТС – Улаанбаатарын цахилгаан түгээх
сүлжээ
ЭХҮ – Эрчим хүчний үйлдвэр
ДБЯ – Дэд бүтцийн яам
СЭЗЯ – Санхүү, эдийн засгийн яам
СЭЗС – Санхүү, эдийн засгийн сайд
СЯ - Сангийн яам
ДМ - Дойчмарк

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд эрчим хүчний салбарт Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, хандивлагч орны зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалт, гадаад зээлийн буцаан төлөлтөд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Энэхүү аудитын зорилт нь дараахь чиглэлээр аудит хийж дүгнэлт, зөвлөмж өгөхөд чиглэгдсэн болно. Үүнд:

1. Эрчим хүчний салбарт гадаадын зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалт
2. Эрчим хүчний салбарын гадаад зээлийн буцаан төлөлт
3. Засгийн газраас төслийн зээлийн хэрэгжилтэд тавьсан хяналт

Аудитад СЯ, ТЭХЯ, Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв, 2,3,4 дүгээр ДЦС, Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, Дарханы ДЦС, Тайширын УЦС, “Эрчим” импекс, Дулааны шугам, сүлжээний газар тус тус хамрагдлаа.

Аудитыг гүйцэтгэхдээ СЯ, ТЭХЯ болон төсөл хэрэгжүүлж байгаа нэгж, байгууллагаас авсан мэдээлэл, баримт материалыг хянах, ярилцлага хийх, түүвэрчилсэн судалгаа хийх, тулган баталгаажуулах зэрэг гүйцэтгэлийн аудитын горимуудыг ашигласан болно.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дараахь хууль, тогтоомжийг аудитын шалгуурын эх үүсвэр болгон ашиглалаа. Үүнд:

- Засгийн газар хоорондын зээлийн гэрээ, хэлэлцээр, протокол, холбогдох бусад бичиг баримт
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хууль

Ерөнхий зүйл

- Дэд бүтцийн хөгжлийн сайдын (хуучин нэрээр) 2001 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 121 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсын дэд бүтцийн салбарт гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулах журам”
- СЭЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын яам дундын тендерийн хорооны болон үнэлгээний хэсгийн гишүүдийг томилсон тушаал, тендерийн бичиг баримт, үнэлгээний хэсгийн дүгнэлт, тендерийн хорооны хурлын шийдвэр, протокол
- СЯ болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хооронд байгуулсан дамжуулан зээлдэх гэрээ
- Японы олон улсын хамтын ажиллагааны банк (ЯОУХАБ)-наас 2000 оны 6 дугаар сард гаргасан “ЯОУХАБ-ны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд явагдах тендер, түүний үнэлгээний заавар”

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөг мөрдөж ажиллав.

Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйл, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын 2 дугаар хэлтсийн дарга, тэргүүлэх аудитор О.Мэндбаяр удирдаж, тус хэлтсийн ахлах аудитор С.Гансүх, аудитор А.Сүхбаатар, И.Туяа, Б.Баттуяа болон Дархан-Уул аймгийн Аудитын газрын ахлах аудитор Л.Дамдинжав нар 2005 оны 5-8 дугаар сард гүйцэтгэв.

Аудитын дүн

Эрчим хүчний салбарт гадаадын зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалт

Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсээс 2005 оны 2 дугаар сард гаргасан судалгаагаар Монгол Улс 1991-2004 онд нийт 1555.0 сая ам.долларын зээлийг хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас авч ашигласан байна. Үүний 933.3 сая ам.доллар буюу 60 хувийг дэд бүтцийн салбарт зарцуулсан байна.

Дэд бүтцийн салбарт ашигласан зээлийг дотор нь ангилж үзвэл 37.5 хувийг зам тээвэрт, 20.7 хувийг эрчим хүчинд, 15.9 хувийг үйлдвэр барилгад, 12.2 хувийг уул уурхайд, 8.3 хувийг харилцаа холбоонд, 5.4 хувийг орон сууц, нийтийн аж ахуйд тус тус авч ашигласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль батлагдахаас өмнө буюу 2000 оны 4 дүгээр сараас өмнө эрчим хүчний салбарт хэрэгжүүлсэн төслүүдийн гүйцэтгэгчийг Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу хандивлагч орны санхүүгийн байгууллагаас гаргасан заавар, журмыг баримтлан сонгон шалгаруулжээ.

Тухайлбал, Улаанбаатар хотын 4 дүгээр цахилгаан станцыг шинэчлэх төслийн гүйцэтгэгчийг сонгохдоо Монгол Улсын Засгийн газар болон Япон Улсын ГЭЗТХАС-тай 1996 онд байгуулсан гэрээний дагуу “ЯОУХАБ-ны Далайн чанад дахь хөгжлийг дэмжих туслалцааны зээлд зориулсан заавар”-ыг мөрдөхөөр заажээ. Мөн Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд 1998-2002 онд Япон Улсын ГЭЗТХАС-гийн зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн төслийн гүйцэтгэгчийг сонгохдоо дээрх зааврыг баримтлахаар гэрээнд заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль батлагдсанаас хойш олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг мөрдөхөөр заажээ. Үүний дагуу төслийн гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй тендер, олон улсын хязгаарлагдмал тендер, шууд гэрээгээр тус тус сонгон шалгаруулж ирсэн байна.

Аудитад хамрагдсан 7 төсөлд 22 тендер зарлагдаж, гадаадын 49, дотоодын 40 компани (давхардсан тоогоор) тендерийн шалгаруулалтад оролцжээ (Хавсралт 1).

Төслүүдийн тендерийн бичиг баримтыг олон улсын тендерээр шалгарсан Зөвлөх компани боловсруулж, багцаар хийх ажлын жагсаалтыг үнийн дүнтэй бэлтгэж ирсэн байна. Зөвлөх компанид ихэвчлэн гадаадын компаниуд шалгарч, туслан гүйцэтгэгчээр дотоодын компани ажиллажээ.

Аудитын дүн

Ихэнх төслийн тендерийн шалгаруулалт тендерийн хууль, журмын дагуу явагдсан боловч зарим төслийн тендер хууль зөрчин явагджээ.

Тухайлбал, “Түгээх сүлжээний алдагдлыг бууруулах” төслийн шалгаруулалтад 5 компани оролцсоноос 4 компаний техникийн бичиг баримт шаардлага хангаагүй учраас хасагдаж, зөвхөн “МТЕ” компани үлдэн үнийн хувьд бусад компаниудаас 6 дахин их үнийн санал ирүүлсэн боловч ДБ-ны саналыг үндэслэн шалгаруулжээ.

Ингэж ямар ч өрсөлдөгчгүй гүйцэтгэгч шалгаруулсан нь хийгдэх ажлын чанар, тоо хэмжээ, худалдан авч байгаа тоног төхөөрөмжийн чанар, үнийн сонголтод сөргөөр нөлөөлж, зээлийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчимд харшилж, тендерийн хорооны шийдвэрийг зээл олгогч байгууллагын саналаар өөрчилсөн буруу үйлдэл болжээ.

Тендерийн үнэлгээний хэсгээс гаргасан зарим багцын талаархи шийдвэр нь хэт ерөнхий, зөвхөн хамгийн бага үнийн санал өгсөн компани нь ялагчаар сонгогдох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тухайлбал, Улаанбаатар хотын дулааны 4 дүгээр цахилгаан станцыг шинэчлэх төслийн 2 дугаар шатны 7 дугаар багцын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн үнэлгээний хэсгийн 2003 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хурлын протоколд техникийн шаардлага болон санхүү, эдийн засгийн шаардлага, нөхцөлд нийцсэн, хамгийн сайн, хямд үнэлэгдсэн санал ирүүлсэн “Мегаватт” ХХК-ийг гэрээ байгуулах хэлэлцээрт урихаар шийдвэрлэжээ. Дээрх шийдвэрт бусдаасаа хамгийн сайн санал ирүүлсэн гэж дүгнэж байгаа боловч юугаараа хамгийн сайн байсан талаар тодорхой дурдаагүй байлаа.

Улаанбаатар хотын дулааны 4 дүгээр цахилгаан станцын засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерт “MCS”, “Мегаватт ХХК”, “Хасу ХХК” гэсэн дотоодын 3 компани голлон оролцсон байна. Тендерт оролцох хуулийн этгээдэд тавигдах шаардлагад тухайн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тендерт оролцож гүйцэтгэгчээр ажиллаж байсан компанийг оролцуулахаар заасан нь шинээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг оруулахыг хязгаарласан, хэдхэн том компаниудыг дэмжсэн заалт болсон байна.

Аудитын дүн

Эрчим хүчний салбарын гадаад зээлийн буцаан төлөлт

Эрчим хүчний салбарт Засгийн газрын шугамаар 1991-2004 онд 193.2 сая ам.долларын зээлийг ашиглаад байна.

- Зээлээр хэрэгжүүлсэн төслийн үндэслэл, зорилт, хэрэгцээ шаардлага

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хуучин ЗХУ-ын техник, эдийн засгийн тусламжаар баригдсан эрчим хүчний салбарын үйлдвэр, аж ахуйн газруудад ажиллаж байсан мэргэжилтнүүд нутаг буцсан, ирж байсан зээл тусламж зогсож, урьд нь байнга хангагдаж байсан тоног төхөөрөмж, техник хэрэгслийн үнэ нэмэгдэж, нийлүүлэлт хомсдон, ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн эдэлгээний хугацаа дууссанаас элэгдэл ихсэж, хэвийн ажиллагаа доголдон аваарын байдалтай ажиллаж эдийн засгийн үр ашиг буурч ирсэн байна.

Тухайлбал, 1995 онд ДЦС-3-т тэсрэлт 15 удаа, аваарын саатал 110 удаа, ДЦС-4 ашиглалтад орсны дараах 2 дахь жилээс зуухнуудын тоос бэлтгэх систем доголдож, тоосны шугамын булангууд цоорох зэргээр байнга гэмтэл гарах болсон байна. 1996 онд зуух аваарын байдлаар 161 удаа зогсож 221.3 сая квт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх боломжоо алдсан байна.

Дулааны станцууд чийглэг ихтэй нүүрс түлэх технологитой болсон тул Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг шинэчлэх, эдийн засгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага гарсан байна.

Иймээс эрчим хүчний салбарын хэвийн үйл ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас хандивлагч орон, олон улсын байгууллагаас өгсөн зээлийн зарим хэсгийг тус салбарт оруулсан байна.

- Зээлийн гэрээний нөхцөл, талуудын үүрэг хариуцлага, хэрэгжилт,

Монгол Улсын Засгийн газар АХБ, ДБ болон хандивлагч орнуудаас эрчим хүчний салбарын шинэчлэлд зориулан 193.2 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэй 30-40 жил төлөх, ингэхдээ эхний 7-10 жилд үндсэн зээл төлөхөөс чөлөөлөгдөж дараагийн 20-23 жилд үндсэн зээлийг хүүгийн хамт бүрэн төлж барагдуулах нөхцөлөөр авчээ. Эрчим хүчний салбарт олгосон зээлийн эхний төлбөр 2004 оноос хийгдэж эхэлжээ.

Ихэнх зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж СЯ, ЭХУГ хийж ирсэн байна.

Аудитын дүн

СЭЗС-ын 2001 оны 218 дугаар тушаалаар батлагдсан “Гадаад орон, олон улсын байгууллагуудаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар авах зээлийг дотоодод дамжуулан зээлдэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу зээл ашиглагч байгууллагуудтай дамжуулан зээлдэх гэрээг хийж иржээ.

Дамжуулан зээлдэх гэрээгээр тухайн зээл ашиглагч байгууллагын үндсэн зээлийн төлбөр хийх хугацаа багасч, жилийн төлөх хүү нэмэгдсэн байна.

Тухайлбал, СЯ дамжуулан зээлдэх гэрээг хийхдээ “Эрчим хүчний хөтөлбөр-1” төсөлд АХБ-наас олгосон зээлийг дамжуулан зээлдэх гэрээнд 40 жилийн хугацаатай, эхний 10 жил үндсэн зээлээс чөлөөлөгдөж 2007 оны 4 дүгээр сарын 15-наас үндсэн зээл төлөх нөхцөлийг өөрчлөн зээлийн үндсэн өрийг 2004 оны 6 дугаар сарын 15-наас эхлэн 20 жилийн дотор хуваарийн дагуу төлөх гэрээ хийжээ. Мөн “Түгээх сүлжээний алдагдлыг бууруулах” төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээг дээрх байдлаар хийснээс гадна үндсэн зээлийн гэрээнд заасан жилийн 0.75 хувийн хүүг 5.0 хувь болгон өсгөж “УБЦТС” ХК-тай дамжуулан зээлдэх гэрээ хийжээ.

Эрчим хүчний салбарт хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүнд цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цахилгаан станцууд, уул уурхайн салбарын хэвийн ажиллах нөхцөл бүрдэн, техник технологийн шинэчлэл хийгдэж эхэлсэн байна.

Тухайлбал, ДЦС-4 дээр хэрэгжсэн зуухны тоосон болон удирдлагын системийг шинэчлэх төслийн 1 дүгээр шатанд 1,2,3,4 дүгээр зуухны завсрын тоосны бункертэй тоос бэлтгэх системийг шууд үлээлттэй системд, автомат удирдлагын системийг технологийн хувьд шинэчлэн орчин үеийн програм хангамжтай нэг сувагт удирдлагын автомат системд шилжүүлсэн байна.

Япон Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг хөгжүүлэх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх төслийн хүрээнд уурхайн техник, тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, нүүрс ачих ялгах байгууламж шинээр баригдаж, уурхайг өргөтгөн шинэчлэх, ингэснээр эрчим хүчний гол эх үүсвэр болсон нүүрсний чанарыг сайжруулах, нүүрсний дутагдлыг арилгах арга хэмжээ авагдсан байна.

Гэвч зарим төслийн хувьд тоног төхөөрөмж, хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээний үнэ хэт өндөр, дамжуулан зээлдэх гэрээ одоо болтол хийгдээгүй, зарим ажил хугацаа алдан хэрэгжиж байгаа дутагдлууд аудитаар илэрлээ.

Тухайлбал, Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд Япон

Аудитын дүн

Улсын хөнгөлөлттэй зээлээр 1998-2002 онд хэрэгжсэн төслийн хүрээнд 226.9 сая иений үнэтэй Чойр-Хар-Айрагийн 110 кВ-ийн цахилгаан дамжуулах 18.3 км шугам, 260.9 сая иений үнэтэй Чойр-Шивээ-Овоогийн 110 кВ-ийн 17.2 км цахилгаан дамжуулах шугам, 35.1 сая иений үнэтэй 110 кВ-ийн дэд станцын өргөтгөлийг барьж ашиглалтад оруулж, дамжуулах шугам, дэд станцын өргөтгөлийг Дэд бүтцийн сайдын 2003 оны 80 дугаар тушаалаар “Төвийн цахилгаан дамжуулах сүлжээ” ХК, “Төмөр замын хэрэг эрхлэх газар”, “Шивээ-Овоогийн нүүрсний уурхай”-н өмчлөлд шилжүүлж, шилжсэн байгууламжуудын зээл, зээлийн хүүг өмчлөгч байгууллага хариуцахаар шийдвэрлэсэн боловч энэ шийдвэр одоо болтол хэрэгжээгүй байна.

Хэрэгжээгүй шалтгаан нь байгууламжийн үнэ, зээлийн хүү өндөр, валютын ханшийн алдагдал их байгаатай холбоотой бөгөөд өндөр хүүтэй, их хэмжээний зээлийг хариуцаж чадахгүй гэдгээ дээрх байгууллагууд албан бичгээр мэдэгдсэн байна.

Улаанбаатар төмөр замын ерөнхий инженерийн Төмөр замын хэрэг эрхлэх газрын даргад ирүүлсэн албан бичигт манай байгууллага 110 кВ-ийн 1 км шугамыг 6.0 сая төгрөгийн зардал гарган барьж байхад Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн ашиглалтын талбайгаас шилжүүлж манай байгууллагад өмчлүүлэх 110 кВ-ийн 1 км шугамын үнэ 72 сая төгрөг буюу манай шугамын үнээс 12 дахин өндөр байгааг дурдсан байна.

ДЦС-4-т хэрэгжиж байгаа станцыг шинэчлэх 2 дугаар шатны гэрээний төсөл, хийгдэх ажлын бичиг баримт 2002 онд боловсрогдож дууссан боловч гэрээг соёрхон батлах, зээлдэгч талаас гэрээний санал авах зэрэг үйл ажиллагаанд бараг 2 жил зарцуулсан байна. Үүний улмаас гэрээг хэрэгжүүлэх хугацаа багасаж, хийгдэх ажлууд шахагдан, төслийн зээлийг хугацаанд нь бүрэн ашиглахад зарим талаар сөргөөр нөлөөлж байна.

Зуухны засвар, шинэчлэлтийн ажлыг олон багц болгон хуваан хийж байгаагаас нэг багцын ажил удаашрах нь бусад багцын ажил хугацаа алдахад нөлөөлж байна.

Тухайлбал, 2003 оны 8 дугаар сард боловсруулсан 5 дугаар багцын Тендерийн бичиг баримтад байгаа төсөл хэрэгжүүлэх хуваариар 1 дэх зууханд хийх засвар шинэчлэлийн ажлыг 2004 оны 2 дугаар сард эхэлж 2004 оны 9 дүгээр сард дуусгах байсан боловч уг зуухны ажил 2005 оны 5 дугаар сард буюу 7 сарын дараа хийгдэж дууссан байна.

Тус төслийн 3 дугаар багцад шалгарсан “Эрчим” концерны 7 дугаар зуухны экономайзерийн коллектор, булан, шулуун хэсгүүдийн гагнуурын оёдлуудын 90 хувь гологдол болж дахин

Аудитын дүн

засварлах ажил хийгдсэнээс дараагийн багцын ажил хүлээгдэхэд хүрч байжээ.

Хэрэгжсэн зарим төслийн хөрөнгийн зарцуулалт, эзэн холбогдогч тодорхойгүй, төсөл авч ашигласан зарим байгууллагыг хувьчлахдаа зээлийн хөрөнгийг оруулж тооцоогүйгээс хариуцах эзэн холбогдогч байхгүй, дамжуулан зээлдэх гэрээ хийгдээгүй байна.

Тухайлбал, ХБНГУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 1993 оны 6 дугаар сард байгуулсан хэлэлцээрийн дагуу 2.0 сая ДМ-ийн “Бараа-4” төслийн зээлийг Эрчим хүчний салбарт нийлүүлэх сэлбэг хэрэгсэлд зориулан олгосон байна. СЭЗЯ, “ДДЦС”-ын хооронд байгуулсан 2001 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн протоколоор ДДЦС 1390236.83 ДМ-ийн зээлийг авч ашигласан байна. Үлдсэн 609763.17 ДМ-ийн зээлийг хэн авч ашигласан нь тодорхойгүй байна.

“Бараа-4” төслийн 2.0 сая ДМ-ийн зээлийн барааг “Эрчим” импексээр дамжуулан хуваарилсан бөгөөд 366063.17 ДМ-ийн зээлийн барааг “Эрчим” импекс өөрөө авч ашигласан гэж дээрх протоколд дурдсан боловч одоо болтол дамжуулан зээлдэх гэрээ хийгээгүй, “Эрчим” импекс 2000 оны 7 дугаар сард хувьчлагдсан байна. Үлдэх 243700.00 ДМ-ийн зээлийн хөрөнгө хаана хуваарилагдаж очсон нь тодорхойгүй байна.

“Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийг хувьчлахдаа АХБ-наас 1997-2001 онд авч ашигласан 36559.90 зээлжих тусгай эрхийн зээлийн хөрөнгийг оруулж тооцоогүйгээс дамжуулан зээлдэх гэрээ хийгдээгүй, зээл төлөгдөх боломжгүйд хүрсэн байна.

“Түгээх сүлжээний алдагдлыг бууруулах” төслийн зээлийн хөрөнгөөр нэг бүрийг 41000.00 ам.доллороор худалдан авсан 2 автомашины нэгийг зөвлөхөд болон аваарын бригадын хэрэгцээнд хэрэглэх ёстой атал төсөл хэрэгжүүлэгч байгууллага болох “УБЦТС” ХК-ийн гүйцэтгэх захирлын хэрэгцээнд зориулалт бусаар ашиглаж байна.

- Зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлт

ДБ, АХБ болон хандивлагч орнуудаас олгосон зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлтийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж СЯ хариуцаж байгаа бөгөөд гүйцэтгэлийн аудитыг СЯ болон ашиглагч байгууллагын хооронд байгуулсан дамжуулан зээлдэх гэрээний хүрээнд хийлээ.

Аудитад хамрагдсан 7 байгууллагаас “ДЦС-3” ХК 3307.7 мянган

Аудитын дүн

зээлжих тусгай эрхийн, “Багануур” ХК 266.6 сая иений, “Шивээ-Овоо” ХК 322.3 сая иений зээлийн хүүгийн, “ДЦС-4” ХК 385.0 сая иений, “ДДЦС” 1252.1 мянган еврогийн зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлт дутуу, хугацаа хэтэрсэн өртэй байна.

СЯ-ны Өрийн удирдлагын хэлтсээс гаргасан мэдээгээр 1991 оноос 2005 оны эхний хагас жилийн байдлаар эрчим хүчний салбарт авч ашигласан болон хэрэгжүүлж байгаа төслийн зээлээс 67,6 тэрбум төгрөгийн зээл, зээлийн хүүг буцаан төлөхөөс 32,0 тэрбум буюу 47,4 хувийг буцаан төвлөрүүлсэн байна (Хавсралт 2).

Зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлт хангалтгүй байгаа нь зээлийн бичиг баримтыг анх боловсруулахдаа эдийн засгийн тооцоо судалгаа дутуу хийснээс гадна зээлийн буцаан төлөлтийг ямар байгууллага хариуцан ямар эх үүсвэрээр төлөх талаар тодорхой заагаагүй, зээл хариуцан төлөх байгууллагууд өөрчлөгдөж байгаатай холбоотой байна.

Төслийн хөрөнгөөр авч ашиглаж байгаа барилга байгууламж, цахилгаан сүлжээ болон бэлтгэн нийлүүлсэн тоног төхөөрөмжийн үнэ нь зах зээлийн үнээс хэт өндөр, борлуулалтын үнэ, тарифыг бодит зардалтай уялдуулан цаг хугацаанд нь шинэчлэн өөрчлөөгүйтэй холбоотой байна.

Эрчим хүчний салбарт хэрэгжүүлж байсан төслийн зээлийн гэрээний үүргийг 1997 оноос 2001 он хүртэл хариуцаж байсан ЭХУГ зээл, зээлийн хүүг төлөх үүргээ биелүүлж ажиллаагүйгээс зээлийн өр хуримтлагдсан байна.

Сангийн яам 2000 оноос эхлэн гадаадын зээл авч ашиглаж байгаа боловч дамжуулан зээлдэх гэрээ байгуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагын зээлийн өрийн үлдэгдлийг тогтоон, гэрээг нөхөн байгуулах, 2002 оноос Улсын төвлөрсөн төсвийн балансад үлдэгдлийг тусгаж, зээлийн буцаан төлөлтийг сайжруулах талаар салбарын яаманд удаа дараа мэдэгдэх зэрэг тодорхой ажлуудыг хийж иржээ.

Зээл, зээлийн хүүгийн буцаан төлөх асуудлыг 2001 оноос зээл авч ашиглаж байгаа байгууллагууд хариуцах болсон байна. Эрчим хүчний салбар хуримтлагдсан өрийг нэг дор бүрэн төлөх боломжгүй байгаагаас зээлийн төлөлт хийх хуваарийг СЯ-ны Өрийн удирдлагын хэлтэстэй тохирон 2005 оноос мөрдөж эхэлжээ.

Зээл буцаан төлөлтөд нөлөөлж байгаа өөр нэг хүчин зүйл нь ханшны өөрчлөлт бөгөөд энэ нь ханшны алдагдлыг ихэсгэж, зээлийн төлөх дүн, эрчим хүчний салбарын эдийн засгийн

Аудитын дүн

үзүүлэлтэд муугаар нөлөөлж байна. Тухайлбал, иенийн ханш огцом нэмэгдсэнээр 1998-2004 онд Шивээ-Овоо ХК 1710.9 сая төгрөгийн бодит бус алдагдал хүлээсэн байна.

- Төслийн зээлийг хэрэгжүүлсэн байгууллагын удирдлагын чадвар, хариуцлага

Түлш, эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламж авч ашиглаж эхэлсэн эхний үед төслийн баримт бичиг боловсруулах, хандивлагч орон, олон улсын болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах туршлага дутмаг, үйл ажиллагаагаа зохицуулах талаар хангалтгүй ажиллаж байснаас гадна боловсон хүчний хэлний болон техникийн мэдлэг, ур чадвар дутмаг байжээ.

Зарим төслийн хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагын ажлын уялдаа холбоо муугаас хийгдэх ажил хугацаа алдаж, нэмэгдэл зардал гарахад хүрч төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.

Тухайлбал, “Түгээх сүлжээний алдагдлыг бууруулах” төслийн захиалагч “УБЦТС” ХК аймгийн “ЭХҮ”-ийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгч нэгж болон гүйцэтгэгчтэй ажлаа уялдуулан зохицуулж чадаагүйгээс ажил удааширч хугацаа алдан, улмаар бараа материалын хадгалалт, тээвэрлэлтийн зардалд 100.1 сая төгрөг нэмж шаардагдаж байгаа бөгөөд тендерийн бичиг баримтад барааны хадгалалт, тээвэрлэлтийн зардлыг нарийн тооцож тусгаагүй байна.

“Тайширын усан цахилгаан станц” төслийн гэрээнд бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөгдөхөөр заасан боловч сумын татварын болон байгаль орчны байцаагч нар ашигт малтмал, автозам ашигласны, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төлбөр зэргийг оногдуулж төлөхийг шаардан ажлыг нь олон хоногоор саатуулж байжээ. Гүйцэтгэлийн аудитын явцад дээрх зөрчлийг арилгаж, ажлыг үргэлжлүүлэн явуулсан болно.

Төслийн зээлийн хэрэгжилтэд тавьсан хяналт

- Төслийн зээлийн гэрээний биелэлт, түүнд тавьж буй хяналт

Төслийн зээлийн хэрэгжилтэд төслийг хэрэгжүүлэгч байгууллага, төслийн нэгж болон төслийн хөрөнгийг авч ашиглаж байгаа байгууллагууд хяналт тавьж ирсэн байна.

Харин зарим төслийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж хяналт тавих үүргээ СЯ, ДБЯ (хуучин нэрээр), ЭХУГ (төсөл гүйцэтгэгч байгууллага) хангалтгүй биелүүлж, зөвхөн

Аудитын дүн

улирал, жилээр гүйцэтгэлийн тайлан мэдээ авахаас хэтрээгүй байна. Төсөл хэрэгжих явцад хийсэн хяналт шалгалт, зөвлөмж өгсөн материал алга байна.

“Тайширын усан цахилгаан станц” төслийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт хангалтгүй байна. Тухайлбал, Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 33 дугаар тогтоолын 2-т Тайширын усан цахилгаан станцыг барьж байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, барилгын материал, машин механизмыг тасралтгүй нийлүүлэх шаардлагыг харгалзан 2008 он хүртэлх хугацаанд “Булган”, “Бургастай”-н хилийн боомтуудыг байнгын ажиллагаатай болгох асуудлыг БНХАУ-ын талтай тохирч холбогдох саналыг боловсруулж шийдвэрлүүлэхээр заасан заалт хэрэгжээгүй байна.

Төслийн удирдах зарим хороо байгуулагдсанаасаа хойш нэг ч удаа хуралдаагүй байна. Тухайлбал, “Эрчим хүчний хөтөлбөр-1” төслийн Удирдах хороог Дэд бүтцийн сайдын 2002 оны 209 дүгээр тушаалаар байгуулсан боловч нэг ч удаа хуралдаагүй төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Монгол Улсын Засгийн газар “Түгээх сүлжээний алдагдлыг бууруулах” төслийн хүрээнд 160.3 мянган ам.доллар гаргах гэрээний үүргээ биелүүлээгүйгээс тоолуур, гүйдлийн трансформаторыг баталгаажуулах ажил хийгдээгүй байна.

“Эрчим хүчний хөтөлбөр-1” төслийн ажилд 7.9 сая еврогийн хөнгөлөлттэй зээл, 1.4 тэрбум төгрөгийн дотоодын санхүүжилт олгохоор төлөвлөгдсөн бөгөөд нэмэлт ажил хийгдвэл дотоодын санхүүжилт 3.6 тэрбум төгрөг болохоор тооцоо гарсан боловч Сангийн яам 2.2 тэрбум төгрөгийн нэмэлт ажлын дамжуулан зээлдэх гэрээг одоо болтол хийгээгүй хаанаас эх үүсвэр гарах нь тодорхойгүй байна.

Дүгнэлт

Гүйцэтгэлийн аудитаар олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, хийсэн дүн шинжилгээ, ажиглалт, судалгаанд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон хандивлагч орнуудаас 2004 оны байдлаар 193.2 сая ам.долларын зээлийг эрчим хүчний салбарт авч ашигласнаар техник, технологийн шинэчлэл хийгдэж цахилгаан станцууд, эрчим хүчний салбар хэвийн ажиллах нөхцөл бүрдсэн байна.

Гэвч зээл авч ашиглаж байгаа байгууллагуудтай зээл буцаан төлөх гэрээг бүрэн хийгээгүй, зарим байгууллагыг хувьчлахдаа зээлийн өрийг оруулж тооцоогүй, зарим зээлийг ямар байгууллага авч ашигласан нь тодорхойгүй, зээлээр авсан зарим тоног төхөөрөмж, хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээний үнэ хэт өндөр байна.

Дотоодын байгууллагад дамжуулан зээлдүүлсэн зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлт 47.4 хувьтай буюу зээлийн өр хуримтлагдсан байна. Сангийн яам дотоодын байгууллагад дамжуулан зээлдүүлэхдээ зээл төлөх хугацааг богиносгон, хүүг нэмэгдүүлж байгаа нь үүнд нөлөөлжээ.

Зарим төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт хууль, журам зөрчсөн, хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагын уялдаа холбоо муу, Монголын талын санхүүжилт хийгдээгүйгээс төлөвлөгдсөн ажлууд удааширсан, төслөөр байгуулсан барилга байгууламжийг авч ашиглах, зээл төлөх байгууллага тодорхойгүй, зарим төслийн удирдах хороо хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Яамнаас ирүүлсэн санал

Сангийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

210645 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 32-02-47, E-mail: aitankhuyag_n@corp.mof.mn
http://www.mof.gov.mn

2005 11.10 № 5-74/3842
танай _____-ны № 281 _____-т

Тоотын хариу

Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар 1991-2005 он хүртэлх хугацаанд авч ашигласан гадаадын зээлийн хөрөнгөнөөс 1,16 тэрбум ам.долларыг нийт 350 гаруй аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлсэн бөгөөд 2005 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 1,000,73 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна.

Энэ хугацаанд Монгол Улсын Засгийн газар зээлийн өртэй аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 111,4 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг улсын төсөвт буцаан төлүүлж, зээлдүүлэгч гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагад нийтдээ 462,7 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлсөн байна.

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл Улсын төвлөрсөн төсвийн балансад 2002 он хүртэл тусгагдаагүй байсан бөгөөд энэ нь тухайн үед зээл авсан аж ахуйн нэгж байгууллага, зээлийн хэмжээ зэрэг нь тодорхой бус, зээлийн гэрээ болон холбогдох бусад бичиг баримт нь олддоггүй байсантай холбоотой юм. 2000 оноос эхлэн 1991 оноос хойшхи хугацаанд Монгол Улсын Засгийн газрын шугамаар авсан гадаад зээлээс дамжуулж зээлсэн аж ахуйн нэгж байгууллагууд болон тэдгээрийн зээлийн өрийн үлдэгдлийг тогтоох, улмаар Дамжуулан зээлийн гэрээ байгуулаагүй байгууллагуудтай гэрээг нөхөн байгуулах, зээлийн буцаан төлөлтийг сайжруулах талаар эрчимтэй ажиллаж эхэлсэний дүнд зээлийн өртэй байгууллагуудын өрийн үлдэгдлийг төсвийн балансад тусгах нөхцөл бүрдэж, эхний ээлжинд Дамжуулан зээлдүүлэх гэрээтэй, зээлийн өрийн үлдэгдэл нь тодорхой байсан эрчим хүчний салбарт Дамжуулан зээлдүүлсэн зээлийн өрийн 143,77 тэрбум төгрөгийн үлдэгдлийг 2002 оны Улсын төвлөрсөн төсвийн балансад тусгасан байна. 2003 онд бусад аж ахуйн нэгж байгууллагуудын өрийн үлдэгдлийн хэмжээг тогтоон, зээлийн буцаан төлөлтийг сайжруулах арга хэмжээг удаа дараа авч хэрэгжүүлснээр 1991-2003 онд зээл авсан бүх аж ахуйн нэгжүүдийн зээлийн өрийн үлдэгдлийг холбогдох баримт материалаар баталгаажуулж, дамжуулан зээлдүүлсэн зээлийн 902,53 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлийг тооцож, Улсын төсвийн балансад тусгуулан ажилласан болно.

Улсын төсөв, санхүүгийн боломж хомс байгаа өнөөгийн нөхцөлд хөгжлийн албан ёсны зээл нь эдийн засгийг хөгжүүлэх үндсэн суурь болж байгаа боловч уг зээлийг буцаан төлөхөд учирч болох төсвийн дарамт, хүндрэлийг урьдчилан тооцож үзэхээс өөр аргагүй байна.

"Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай" Монгол Улсын хуульд гадаадын зээлийг эргүүлэн төлөх дотоодын эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор гадаадын зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэхээр тусгагдсан боловч дамжуулан

зээлдүүлэх зээл авсан аж ахуйн нэгж байгууллагууд алга болох, байр хаягаа өөрчлөх, татан буугдах, дампуурах, төлбөрийн чадваргүй болох зэргээр зээлийн өрийг төсөвт төлөхгүй байгаагаас татвар төлөгчдийн орлогоор төсвийн данснаас гадаад талд төлбөрийг төлж байна. Өөрөөр хэлбэл, зээлийг авч ашигласан байгууллагууд зээлийн төлбөрөө төлөхгүй, тэдний өмнөөс улс төсвийн орлогоос зээлийн төлбөрийг гадаад талд төлж байгаа нь Монгол улсын гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэх нэн аюултай сөрөг үр дагавар болж байна.

1991-2005 онуудад дамжуулан зээлдүүлсэн нийт зээлийн 33,9 хувийг эрчим хүч, уул уурхайн салбар эзэлж байна. 2005 оны эхний хагас жилийн байдлаар энэ салбарт дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн болон хүүгийн буцаан төлөлтөөр гэрээний дагуу 67,6 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрөх ёстойгоос 32,1 тэрбум төгрөг төвлөрч, 35,5 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн өр үүсээд байна. Хугацаа хэтэрсэн өрийн ихэнх хувийг Дарханы дулааны цахилгаан станц (2,0 тэрбум төгрөг), Дорнод бүсийн эрчим хүчний систем (2,3 тэрбум төгрөг), Дулааны 3-р цахилгаан станц (6,5 тэрбум төгрөг), Дулааны 4-р цахилгаан станц (1,8 тэрбум төгрөг), "Багануур" ХК (9,2 тэрбум төгрөг), "Шивээ-Овоо" ХК (6,2 тэрбум төгрөг), Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв (0,9 тэрбум төгрөг), Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (2,3 тэрбум төгрөг) эзэлж байна.

Олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орноос эрчим хүчний салбарт зээл авахдаа дунджаар 1,3 хувийн хүүтэй, 7-10 жилийн хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлөөр авсан бөгөөд дотооддоо дунджаар 2,4 хувийн хүүтэйгээр 5-9 жилийн хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлөөр дамжуулан зээлдүүлжээ.

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь дараах үндсэн шалтгаантай шууд холбоотой байсан гэж үзэж байна. Үүнд:

1. Зээл авсан аж ахуйн нэгж, байгууллагын болон зээлийн өрийн талаар 2001 он хүртэл нэгдсэн мэдээлэл, судалгаа байгаагүй;
2. Зээл авсан аж ахуйн нэгж, байгууллагууд нь хувьчлагдсан, өөрчлөн байгуулагдсан, хэд хэд хуваагдсан, дампуурсан, татан буугдсан, төлбөрийн чадваргүй болсон, архивын материалууд нь устсан, шинэ өмчлөгч нь зээлийг авч ашиглаагүй тул хариуцахгүй гэж мэдэгдэж байгаа;
3. Төрийн өмчийн хороо аж ахуйн нэгж байгууллагыг хувьчлахдаа зээлийн өрийг шинэ өмчлөгч хариуцах талаар шийдвэр болон балансад нь тусгалгүйгээр хувьчилсан;
4. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн ихэнх хувийг валютын тогтмол ханшны системтэй үед буюу 1991-1993 онд ам.долларын ханш 40, 150 байх үед /1993 оны 5 дугаар сарын 28-наас хөвөгч ханшны системд шилжсэн/ олгосон тул валютын ханшны зөрүү ихээхэн гарснаар зарим зээлдэгч ханшны зөрүүг хариуцахгүй гэж байгаа;
5. Гадаадын зээлд зөвлөхийн үйлчилгээний зардал хэт өндөр байгаагаас эргээд төсвөөс тэр хэмжээний зардал гаргахад хүргэж байгаа;
6. Төслийн зээлийн хувьд тоног төхөөрөмжийн үнэ өртөг зах зээлийн үнээс хэт өндөр байгаа зэрэг болно.

Дэд бүтцийн салбарт Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, хандивлагч орны зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалт, эрчим хүчний салбарын гадаад зээлийн буцаан төлөлтийн талаар Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын

Тайлбар 1.1-г үзнэ үү.	<p>хорооны хүсэлтээр хийсэн Үндэсний аудитын газрын тайлантай танилцаад дараахь саналтай байна. Үүнд:</p>
Тайлбар 1.1-г үзнэ үү.	<p>1. 1991-2005 онуудад дамжуулан эзэлдүүлсэн нийт зээлийн 33,9 хувийг эрчим хүч, уул уурхайн салбар эзэлж байгаа бөгөөд 2005 оны эхний хагас жилийн байдлаар энэ салбарт дамжуулан эзэлдүүлсэн зээлийн үндсэн болон хүүгийн буцаан төлөлтөөр гэрээний дагуу 67,6 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрөх ёстойгоос 32,1 тэрбум төгрөг төвлөрч, 35,5 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн өр үүсээд байна. Хугацаа хэтэрсэн өрийн ихэнх хувийг Дарханы дулааны цахилгаан станц (2,0 тэрбум төгрөг), Дорнод бүсийн эрчим хүчний систем (2,3 тэрбум төгрөг), Дулааны 3-р цахилгаан станц (6,5 тэрбум төгрөг), Дулааны 4-р цахилгаан станц (1,8 тэрбум төгрөг), "Багануур" ХК (9,2 тэрбум төгрөг), "Шивээ-Овоо" ХК (6,2 тэрбум төгрөг), Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв (0,9 тэрбум төгрөг), Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (2,3 тэрбум төгрөг) эзэлж байна. Түлш, эрчим хүчний салбарын компаниудын хооронд үүсч хуримтлагдсан өрийг барагдуулах ажлыг зохион байгуулж, өрийн удирдлагыг сайжруулах зорилгоор Сангийн сайд, Түлш, эрчим хүчний сайдын 2004 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 239/37 дугаар хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан, уг ажлын хүрээнд Дарханы дулааны цахилгаан станц, Дорнод бүсийн эрчим хүчний систем, Дулааны 3-р цахилгаан станц, Дулааны 4-р цахилгаан станц, "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК-тай дамжуулан эзэлдүүлсэн зээлийн тооцрог нийлж, эдгээр байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу зээлийг төлөх графикийг шинэчлэн тохирсон. Гэвч 2005 оны эхний хагас жилийн байдлаар дээрх байгууллагууд дахин тохирсон графикаас 1,2 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэнийг тухайн салбарын яаманд удаа дараа мэдэгдсэн боловч эргэн төлөлт сайжрахгүй байгаа тул энэ талаар аудитын тайланд тусгах нь зүйтэй байна.</p> <p>Нөгөөтэйгүүр нийт зээлийн 33,9 хувийг зөвхөн эрчим хүч, уул уурхайн салбарт олгосон байхад аудитын дүгнэлтэнд "зарим хэсэг" гэж тусгасныг бодитой дүгнэлт гэж үзэхгүй байна. Иймд энэ салбарт олгосон зээлд тодорхой ач холбогдол өгөх шаардлагатай байна.</p>
Тайлбар 1.1-г үзнэ үү.	<p>2. Дулааны 4-р цахилгаан станцад хэрэгжиж байгаа "Дулааны 4-р цахилгаан станцыг шинэчлэх" II дугаар шатны төслийн 3 дугаар багцад шалгарсан "Эрчим концерн"-ы 7 дугаар зуухны экономайзерийн коллектор, булан, шулуун хэсгүүдийн гагнуурын оёдлуудын 90 хувь гологдол болж дахин засварлах ажил хийгдсэнээс дараагийн багцын ажил хүлээгдэхэд хүрч байсан нь гүйцэтгэгчийн хариуцлагагүй үйл ажиллагаатай шууд холбоотой тул энэ талаар тайланд тодорхой тусгах хэрэгтэй байна.</p>
Тайлбар 1.2-г үзнэ үү.	<p>3. "Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай" хуулийн 14.1.3 дахь заалтад яам, агентлаг нь өөрийн хариуцсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж дотоод хяналт тавихаар заасан боловч салбарын яамдын хяналт сул байгаа нь төслийг үр ашигтай хэрэгжихэд сөргөөр нөлөөлж байна. Мөн дээрх хуулийн дагуу гадаадын зээлийн талаархи бодлого, дунд хугацааны хөгжлийн стратеги, хэтийн чиглэлд нийцүүлэн тухайн салбар, орон нутгийн хэмжээнд гадаадын зээлээр хэрэгжүүлэх төсөл, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтийг тухайн салбарын яам хариуцан боловсруулах ёстой боловч тооцоо судалгаа хангалтгүй хийгддэг зарим тохиолдолд техник, эдийн засгийн үзүүлэлт хийгддэггүй аудитын тайланд тодорхой тусгах саналтай байна.</p> <p>4. Зарим төсөл, хөтөлбөрүүдэд заасан Монголын талаас гаргах санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын орлогоос</p>

Тайлбар 1.3-г
үзнэ үү.

тодорхой хувиар гаргуулж байх талаар аудитын тайланд тусгаж, асуудал тавих нь зүйтэй.


5. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл Улсын төвлөрсөн төсвийн балансад 2002 он хүртэл тусгагдаагүй, тухайн үед зээл авсан аж ахуйн нэгж байгууллага, зээлийн хэмжээ зэрэг нь тодорхой бус, зээлийн гэрээ болон холбогдох бусад бичиг баримт нь олддоггүй байснаас 2000 оноос эхлэн 1991 оноос хойшхи хугацаанд Монгол Улсын Засгийн газрын шугамаар авсан гадаад зээлээс дамжуулж зээлсэн аж ахуйн нэгж байгууллагууд болон тэдгээрийн зээлийн өрийн үлдэгдлийг тогтоох, улмаар Дамжуулан зээлийн гэрээ байгуулаагүй байгууллагуудтай гэрээг нөхөн байгуулах, зээлийн буцаан төлөлтийг сайжруулах талаар эрчимтэйгээр ажиллаж эхэлсэний үр дүнд зээлийн өртэй байгууллагуудын өрийн үлдэгдлийг төсвийн балансад тусгах нөхцөл бүрдэж, эхний ээлжинд Дамжуулан зээлдүүлэх гэрээтэй, зээлийн өрийн үлдэгдэл нь тодорхой байсан эрчим хүчний салбарт Дамжуулан зээлдүүлсэн зээлийн өрийн 143,77 тэрбум төгрөгийн үлдэгдлийг 2002 оны Улсын төвлөрсөн төсвийн балансад тусгасан тухай болон 2003 онд бусад аж ахуйн нэгж байгууллагуудын өрийн үлдэгдлийн хэмжээг тогтоон, зээлийн буцаан төлөлтийг сайжруулах арга хэмжээг удаа дараа авч хэрэгжүүлснээр 1991-2003 онд зээл авсан бүх аж ахуйн нэгжүүдийн зээлийн өрийн үлдэгдлийг холбогдох баримт материалаар баталгаажуулж, дамжуулан зээлдүүлсэн зээлийн 902,53 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлийг тооцож, Улсын төсвийн балансад тусгуулан ажилласан зэрэг тодорхой үр дүнг аудитын дүгнэлтэнд тусгах зайлшгүй шаардлагатайг анхаарч авч үзэхийг хүсье.



A handwritten signature in blue ink, appearing to be 'Н.АЛТАНХУЯГ'.

Н.АЛТАНХУЯГ

Түлш, эрчим
хүчний яам



**МОНГОЛ УЛСЫН
ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**
210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын III байр,
Утас/Факс: 31-81-69


2005.11.10 № а/1927
төний 10/Б -ны № 280 -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Дэд бүтцийн салбарт зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалт, эрчим хүчний салбарын гадаад зээлийн буцаан төлөлтөд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал, төлбөр зохих зээл, хүүгийн төлбөр болон төслүүдийн хэрэгжилтийн талаар зарим тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 12 хуудас
Хянан шийдвэрлэнэ үү.


Т.ОЧИРХҮҮ



**Дэд бүтцийн салбарт Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк,
хандивлагч орны зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн
шалгаруулалт, эрчим хүчний салбарын гадаад зээлийн буцаан
төлөлтөд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд
өгөх санал, тайлбар**

Дэд бүтцийн салбарт Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, хандивлагч орны зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалт, эрчим хүчний салбарын гадаад зээлийн буцаан төлөлтөд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараахи санал, тайлбарыг өгч байна.

Нэг. Дэд бүтцийн салбарт гадаадын зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалтад хийсэн аудитын дүнгийн талаар

1. Тайлангийн төслийн энэхүү хэсэгт дэд бүтцийн салбарын 1991-2004 оны гадаад зээлийн 20.7 хувийг эрчим хүчинд авч ашигласныг дурдсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль батлагдахаас өмнө буюу 2000 оны 4 дүгээр сараас өмнө дэд бүтцийн салбарт хэрэгжүүлсэн төслүүдийн гүйцэтгэгчийг Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан заавар, журмыг баримтлан сонгон шалгаруулж ирсэн бөгөөд уг хууль батлагдсанаас хойш олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол дээрх хуулиар олон улсын нээлттэй болон хязгаарлагдмал тендер, шууд гэрээгээр тус тус сонгон шалгаруулж ирсэн билээ. Аудитад хамрагдсан 8 төслийн хүрээнд 22 тендер зарлагдаж, гадаадын 49, дотоодын 40/давхардсан тоогоор/ тендерийн шалгаруулалтад оролцсон бөгөөд шалгаруулалт үндсэндээ хууль, журмын дагуу явагдсаныг тэмдэглэсэн байна. Түүний хамт зарим тендерийн хувьд үнэлгээний хэсгээс гаргасан шийдвэр ерөнхий, өрсөлдөгчгүй гүйцэтгэгч шалгаруулснаас ажил, үйлчилгээ, тоног төхөөрөмжийн чанар, тоо, хэмжээ, зээлийн хөрөнгийн хэмнэлтэд сөргөөр нөлөөлсөн, тендерт оролцох хуулийн этгээдэд тавигдах шаардлагад тухайн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж өмнө нь

гүйцэтгэгчээр ажиллаж байсан компаниудыг оролцуулахаар зааж, шинээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын оролцоог хязгаарласан тухай дүгнэж бичсэнийг анхааралдаа авч байна.

2. Дэлхийн банкны "Эрчим хүчний төсөл"-ийн хүрээнд зарлагдсан "Цахилгаан тоолуур шалгах төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах" ICB 0103 тоот олон улсын тендерт China National Electric Wire & Cable Import and Export Corporation (CNEWC) 112731 US\$, Northeast China International Electric Power Corporation (NEIE) 165734 US\$, SMS 207900 US\$, Meter Test Equipment AG (MTE) 728804 US\$, Эрчим инженеринг ХХК 749970 US\$-ын үнийн санал тус тус ирүүлсэн бөгөөд үнэлгээний явцад нийлүүлэхээр санал болгосон стэндийн марк, типүүдийг тодорхой болгох, санал болгосон үнэндээ багтааж шаардлага хангасан стэнд нийлүүлж чадах эсэх талаар тодруулгуудыг авсан байна. Бага үнийн санал ирүүлсэн оролцогчидоос CNEWC болон NEIE нь техникийн шаардлага хангаагүй, SMS нь тендерийн баталгаа нь үнийн саналдаа хүрээгүй, санхүүгийн тайлан тэнцэлгүй, гүйдлийн трансформатор шалгах стэндийн техникийн материалгүй гэсэн шалтгаанаар, Эрчим инженеринг ХХК техникийн шаардлагуудыг хангасан боловч санал болгосон зөөврийн стэнд нь 3 хэсэг тоноглолыг угсарч ашигладаг, жингийн хувьд /82кг/ зөөврийн байх гэсэн нөхцлийг хангахгүй, санал болгосон үнэ нь MTE-ээс 21166 US\$-ийн зөрүүтэй гэсэн шалтгаануудаар тус тус үнэлгээ авч чадаагүй байна.

Шалгарсан MTE нь техникийн шаардлагуудыг бүрэн хангасан, зөөврийн төхөөрөмжийн жин 18 кг, 1 иж бүрдэлтэй, шаардлага хангасан Эрчим инженеринг ХХК-аас бага үнийн саналтай байсан байна.

Үнэлгээний хэсгээс оруулсан санал нь төсөвлөгдсөн үнээс хэтэрсэн тул уг тендерийг цуцлах шийдвэрийг Яам дундын тендерийн хорооны 2003 оны 3 сарын 10-ны өдрийн хурлаас гаргаж, мөн төлөвлөхдөө зах зээлийн судалгаа хийгээгүй байна гэсэн шүүмжлэлийг өгсөн болно.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь зохих шугамын дагуу Дэлхийн банканд холбогдох материалуудыг явуулж, Дэлхийн банкнаас "Тоолуурын стэнд нь байнгын үйлдвэрлэлтэй бараа биш тул үнэнд зах зээлийн судалгаа хийх шаардлагагүй, зарласан тендер нь өөрийн зах зээлийн судалгаа болж өгч байна. Дэлхийн банкны бараа материал худалдан авах ажиллагааны

зааварт өрсөлдөөн гараагүй, ирсэн саналууд шаардлагад нийцээгүй гэсэн хоёр шалтгаанаар тендерээс татгалзах заалттай бөгөөд ийм нөхцөл бүрдээгүй байна” гэсэн хариуг өгсөн байна.

Ийм учир Санхүү эдийн засгийн яам/хуучин нэрээр/, Дэд бүтцийн яам/хуучин нэрээр/ дундын тендерийн хорооны 2003 оны 7 сарын 25-ны өдрийн хурлаас Швейцарийн МТЕ-г шалгаруулахаар шийдвэрлэн Дэлхийн банк 2003 оны 8 сарын 5-ны өдөр үл татгалзах өгсөн байна. Гэхдээ энэ компанийн үнийн санал хамгийн өндөр байсан нь зээлийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зарчимд харшилж буй талаар аудитын дүнд дурдсаныг тус яамны зүгээс Дэлхийн банкинд танилцуулж, цаашид тендерийн хорооноос гарах шийдвэрт хяналт тавин ажиллах болно.

Хоёр. Эрчим хүчний салбарын гэдээд зээлийн буцаан төлөлтөд хийсэн аудитын дүнгийн талаар

1. Зээлээр хэрэгжүүлсэн төслийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжих явцад хуучин ЗХУ-ын техник, эдийн засгийн тусламжаар баригдсан эрчим хүчний салбарын үйлдвэр, аж ахуйн газруудад тоног төхөөрөмж, сэлбэг, хэрэгслийн нийлүүлэлт хомсдон, хэвийн ажиллагаа нь доголдон аваарын байдалтай ажиллаж эдийн засгийн үр ашиг буурч ирсэнийг зөв зүйтэй дүгнэсэн байна. Тухайлбал, 1995 онд ДЦС-3-т тэсрэлт 15 удаа, аваарын саатал 110 удаа, ДЦС-4-д зуухнуудын тоос бэлтгэх систем доголдох зэргээр гэмтэл байнга гарч байсан, 1996 онд зуух аваарын байдлаар 161 удаа зогсож 221.0 сая квт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх боломжоо алдсан байна. Энэ нөхцөлд цахилгаан станцуудын зуух, тоног төхөөрөмжийг яаралтай шинэчлэх, хэрэгцээт сэлбэг, материалаар хангах зайлшгүй шаардлага гарсан юм. Түүний хамт Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг шинэчлэх шаардлага гарсан байна. Иймээс эрчим хүч, улмаар эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагааг хангах, үр ашгийг нь дээшлүүлэх зорилгоор Засгийн газар хандивлагч орон, олон улсын

Тайлбар 2.1-г үзнэ үү.

Тайлбар 2.2-г
үзнэ үү.

байгууллагаас олгосон зээлийн зарим хэсгийг тус салбарт зориулах бодит шаардлага байсан тухай аудитын дүнд тусгасныг дэмжиж байна.

2. *Зээлийн гэрээний нөхцөл, талуудын үүрэг, хариуцлага, хэрэгжилт*

Засгийн газар Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон хандивлагч орнуудаас эрчим хүчний салбарын шинэчлэлд зориулан 193.2 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэйгээр 30-40 жилд багтаан төлөх, ингэхдээ эхний 7-10 жилд үндсэн зээл төлөхөөс чөлөөлөгдөж үлдсэн жилүүдэд үндсэн зээлийг хүүгийн хамт бүрэн төлж барагдуулах нөхцөлөөр авсан бөгөөд ихэнх зээлийн гэрээг Засгийн газрыг төлөөлж Сангийн яам, Эрчим хүчний удирдах газар хийж ирсэн тухай тайлангийн төслийн энэ хэсэгт заасан байна. Зээл ашиглагч байгууллагуудтай уг зээлийн дамжуулан зээлдэх гэрээг Санхүү, эдийн засгийн сайд/хуучин нэрээр/-ын 2001 оны 218 дугаар тушаалаар батлагдсан "Гадаад орон, олон улсын байгууллагуудаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар авах зээлийг дотоодод дамжуулан зээлдэх үйл ажиллагааг зохицуулах журам"-ын дагуу хийж ирсэн байна.

Тайлангийн төсөлд дамжуулан зээлдэх гэрээгээр тухайн зээл ашиглагч байгууллагын зээлийн төлбөр хийх хугацааг зээлийн гэрээнийхээс ихээхэн богиносгож, жилийн төлөх хүүгийн хэмжээг нэмэгдүүлснийг тодорхой төслүүдээр жишээ болгон тусгасан байна. Үүн дээр нэмж тодруулга хийхэд "Монгол нүүрс", "Эрчим хүчний хөтөлбөр-1", "Түгээх сүлжээний алдагдал бууруулах" төслүүдийн дамжуулан зээлдэх гэрээнд зээлийн хүүг олон улсын байгууллага, гадаад орноос авсан зээлийн үндсэн хүүгээс 3-4.75 хувиар өсгөсөн, Дарханы ДЦС-ын шинэчлэлт-1, "Монгол нүүрс", "Чойбалсангийн ДЦС-ын шинэчлэлт", "Эрчим хүчний хэмнэлт" төслийн дамжуулан зээлдэх гэрээнд зээл ашиглагч байгууллагын зээлийн төлбөр хийх хугацааг 10-14 жилээр богиносгосон байна. Судалгаанаас үзэхэд зарим төслийн хувьд үндсэн зээлийн хүүгээс дамжуулан зээлдэх гэрээний хүүгийн хэмжээ 3-6.3 дахин их байгаа юм. Хүүгийн энэ зөрүү компаниудын жилийн төлбөрийн дүнг (2005 оны 1 дүгээр сарын 1-ний ханшаар тооцоход) 6.9 тэрбум гаруй төгрөгөөр нэмэгдүүлж байна.

Холбогдох компаниуд энэхүү хүүгийн төлбөрийн зэрэгцээ зээлийн үндсэн төлбөрийг 2004 оноос төлж эхэлсэн нь тэдгээрийн санхүүгийн байдалд ихээхэн дарамт учруулж байна. Түүний хамт түлш, эрчим хүчний үйлдвэрүүдэд хэрэгжсэн нэлээд төслүүдийн зээлийн үндсэн төлбөр 2005 оноос төлөгдөж эхлэх хуваарьтай байгаа нь мөнгөн хөрөнгийн хэрэгцээг улам нэмэгдүүлэх болж байгаа юм.

Улаанбаатарын дулааны сүлжээ ХК дамжуулан зээлдэх гэрээг нь төвлөрүүлэн хийсэн "Эрчим хүчний хэмнэлт" болон "Дулааны үр ашиг"-ийн төслүүдийг хэрэгжүүлэхэд гаргах дотоодын санхүүжилтыг эрчим хүчний үйлдвэрүүд хариуцах нөхцөлтэйгээр дамжуулан зээлдэх гэрээний хүүг үндсэн зээлийн хүүгийн төвшинд буюу 2 хувь байхаар шийдвэрлэсэн хэдий ч энэ нь тухайн компанийг дамжуулан зээлдэх гэрээний хүүний дарамтаас чөлөөлж чадаагүй юм.

Түлш, эрчим хүчний салбарт гадаад орон, олон улсын байгууллагаас авсан зээл, түүний хүүг түлш, эрчим хүчний үйлдвэрүүд Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдэх гэрээ, графикайн дагуу төлж байгаа боловч дамжуулан зээлдэх гэрээний хэрэгжилттэй холбогдсон дараахи асуудлууд гарч байна. Үүнд:

- Валютын ханшийн эрсдэлийг зээл авсан компаниуд шууд хариуцаж байгаа билээ. Гэлцхүү гадаад орон, олон улсын байгууллагад төлөх зээл, түүний хүүний ханшийн өөрчлөлтөөс гадна дамжуулан зээлдэх гэрээгээр нэмэгдсэн хүү/улсын төсөвт орох/-гийн төлбөрийг зээл авсан валютын төлбөр хийх үеийн ханшаар тооцож төлүүлж байгаа нь зээлдэгчдийн санхүүгийн чадавхид сөргөөр нөлөөлж байгаа юм;
- Өнөөгийн мөрдөгдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн хууль, бүртгэлийн стандарт журмын дагуу зээлийн хүүг бүтээгдэхүүний өөрийн өртөг, зардалд төлөөлөж тайлагнадгийг үндэслэн түлш, эрчим хүчний үйлдвэрүүдэд учирч байгаа дээрх эрсдэлийг нөхөхийн тулд нүүрс, цахилгаан, дулааны үнийг дэс дараатай нэмэгдүүлэх шаардлагатай боловч энэ нь эцсийн дүндээ хүн амын орлогын төвшингөөр хязгаарлагдах учраас ийм боломжийг тус салбарын үйлдвэрүүдэд хараахан олгохгүй байгаа билээ;

- Дамжуулан зээлдэх гэрээний хүүг гадаад орон, олон улсын байгууллагаас авсан зээлийн үндсэн хүүгээс өсгөж тогтоосон нь салбарын эдийн засгийн үр ашигт сөргөөр нөлөөлсөөр байна;
- Дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүг өндөр тогтоож байгаа болон валютын ханшийн өсөлт нь түлш, эрчим хүчний үйлдвэр хооронд төдийгүй үйлдвэр, санхүүгийн байгууллага хооронд өр, авлагын сүлжээ үүсгэж, жилээс жилд өсөн нэмэгдэхэд нөлөөлж байгаа юм;
- Гадаад орон, олон улсын байгууллагын зээлээр өргөтгөл, шинэчлэл хийсэн үйлдвэрүүдийн эдийн засгийн үр ашиг хангалтгүй, эргэлтийн хөрөнгөөр байнга дутагдаж байгаа нь төслийн хүрээнд авсан тоног төхөөрөмж, технологийн засвар үйлчилгээг заавар, журмын дагуу цаг хугацаанд нь хийж чадахгүйд хүрч, энэ нь тэдгээрийн ашиглах хугацаа, найдвартай ажиллагаанд нь сөрөг нөлөө үзүүлж байгаа юм.

Тайлангийн төсөлд урьд өмнө хэрэгжсэн зарим төслийн хувьд дамжуулан зээлдэх гэрээ хийгдээгүй, зарим ажил хугацаа алдан хэрэгжиж байгаа дутагдал илэрснийг дурдсан байна.

"Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийг хувьчлахдаа АХБ-наас 1997-2001 онд авч ашигласан 36560.0 Зээлжих тусгай эрхийн зээлийн хөрөнгөөр суурилагдсан тоног төхөөрөмжүүдийг хөрөнгийн дүнд оруулан тооцсон боловч зээлийн өрийг шинэ өмчлөгчид хариуцуулж өгөөгүй, Төрийн өмчийн хорооноос компанийн шинэ эзэдтэй байгуулсан гэрээний "Батламж бичиг" зээлийн өрийн талаар дурдаагүй байснаас "ДСЦТС" ХК нь үндсэн зээл, зээлийн хүү төлүүлэх асуудлаар "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-тай гэрээ хийж, төлбөр хийхээс татгалзаж байсныг Төрийн өмчийн хороо, Сангийн яаманд уламжлан дамжуулан зээлдэх гэрээг хийлгэсэн болно.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд Япон Улсын хөнгөлөлттэй зээлээр 1998-2002 онд хэрэгжсэн төслийн хүрээнд 226.9 сая иений өртөгтэй Чойр-Хар-Айрагийн 110кВ-ийн цахилгаан дамжуулах 18.3 км шугам, 260.9 сая иений үнэтэй Чойр-Шивээ-Овоогийн 110кВ-ийн 17.2 км цахилгаан дамжуулах шугам, 35.1 сая иений өртөгтэй 110кВ-ийн дэд станцын өргөтгөлийг барьж ашиглалтад оруулан, дамжуулах шугам, дэд станцын

өргөтгөлийг Дэд бүтцийн сайд/хуучин нэрээр/-ын 2003 оны 80 дугаар тушаалаар "Төвийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК, "Төмөр замын хэрэг эрхлэх газар", "Шивээ-Овоогийн нүүрсний уурхай"-н өмчлөлд шилжүүлж, эдгээр байгууламжуудын зээл, хүүг өмчлөгч байгууллага хариуцахаар шийдвэрлэсэн боловч энэ шийдвэр одоо болтол хэрэгжээгүй байгаа тухай тайлангийн төсөлд дурдсаны дагуу холбогдох арга хэмжээг энэ онд багтаан авч үзэж шийдвэрлэх болно.

ХБНГУ-ын Засгийн газар, Монгол Улсын засгийн газар хоорондын 1993 оны 6 дугаар сард байгуулсан хэлэлцээрийн дагуу олгосон 2.0 сая DM-ийн "Бараа-4" зээлээс Дарханы ДЦС ХК авч ашигласан 1.4 сая DM-ийн зээлд дамжуулан зээлдэх гэрээ хийсэн бөгөөд үлдсэн 0.6 сая DM-ийн зээл ашигласан эзэн, холбогдогчийг тодруулах асуудлыг Сангийн яамтай хамтран судалж байна.

"Түгээх сүлжээний алдагдал бууруулах" төслийн зээлийн хөрөнгөөр худалдан авсан LAND-105 маркийн суудлын автомашиныг зээлдүүлэгч Дэлхийн банктэй тохиролцсоноор техникийн хяналт, дотоод ажлын зориулалтаар ашиглаж байна.

Аудитын тайлангийн төсөлд дараахи асуудлуудыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

"Даланзадгадын Дулааны Цахилгаан Станц"-ыг Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 1997 оноос эхлэн барих шийдвэр гарч, шавыг 1998 оны 6-р сард тавьсан бөгөөд Хятад улсын WUXI BOILER WORKS үйлдвэрийн 27тн/цаг-ийн уур боловсруулах хүчин чадал бүхий UG-27/3.63-M маягийн 2 зуух, Япон улсад үйлдвэрлэгдсэн 3 Мвт-ийн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай DNG-61-55 маягийн 2 турбогенераторыг цахилгаан, дулаан, нарийн хэмжүүр, автоматик, хими ус бэлтгэлийн тоноглолууд болон бусад цахилгаан, дулааны сүлжээний хамтаар баригдаж 2000 оны 10-р сарын 26-нд ашиглалтад орсон байна. Ашиглалтад орсноос хойш 2005 оны байдлаар нийт 52.3 сая квт цахилгаан, 86.7 мян. Гкал дулааны эрчим хүчийг түгээж 89.4мян. тн нүүрс хэрэглэсэн байна. Дулааны цахилгаан станц нь ялтсан бойлвсроор тоноглогдсон дулаан түгээх 5 төвтэй, газрын гүнээс усаа татдаг 2 насос станцтай бөгөөд 102 км-ийн алсад байгаа Таван толгойн нүүрсний

уурхайгаас нүүрсээ татаж авч байна. Дулааны цахилгаан станц нь 2000 онд 7 удаа, 2001 онд 25 удаа, 2002 онд 15 удаа, 2003 онд 43 удаа, 2004 онд 23 удаа "0" зогсож хэрэглэгчдийг дулаан, цахилгаанаар хязгаарлаж байсан бөгөөд 2002-2004 оны хооронд Даланзадгадын ДЦС-ын үйл ажиллагаатай холбогдуулж нийт 13 ажлын хэсэг ажиллан цаг үеийн хүндрэлтэй асуудлуудыг тухай бүр нь шийдвэрлэж байжээ. Энэ байдлаас үзэхэд "Даланзадгадын ДЦС"-ыг барих төслийн үр дүн бага, ашиглалтад орсон цагаасаа хэрэглэгчдийг дулаан, цахилгаанаар хязгаарлаж ирсэн байна. Үг төслийн хэрэгжилтийн талаар аудитын дүгнэлтэд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн 1995-2000 онд Азийн Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлсэн "Эрчим хүчний шинэчлэлт"-ийн төслийн хүрээнд Италийн Алстом Пауэр компани, Алстом компани, Японы Марубени компаниудын байгуулсан эвсэл Улаанбаатар хотын Дулааны 3 дугаар цахилгаан станцын өндөр даралтын зуухыг шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн юм. Төслийн явцад эдгээр компаниуд нэмэлт зардал гаргасан гэж үзээд түүнийгээ нөхөн төлүүлэхээр 2003 оны 12 дугаар сарын 23-нд Вашингтоны "Хөрөнгө оруулалтын маргааныг таслан шийдвэрлэх олон улсын төв"-д арбитрын нэхэмжлэл гаргасан байна. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу төслийг 1995 онд хэрэгжүүлж эхлэн 1998 оны 1 сард хэрэгжүүлж дуусгах байсан боловч 2000 оны 11 сард дуусгасан байна. Гүйцэтгэгч гэрээгээ зөрчин удаа дараалан ажлаа зогсоож, бараа материалаа хожимдуулан нийлүүлж, туслан гүйцэтгэгчээ хожимдуулан сонгож, төслийг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтын алдаа гаргасан зэрэг олон шалтгаан, хүчин зүйлээс болж төслийн ажилд нэмэлт зардал гарахад хүргэсэн байна. Монгол улсын Ерөнхий сайдын 2004 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 34 тоот захирамжаар уг асуудлын хууль зүйн үндэслэлийг судалж Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөх, тайлбар гаргах ажлын хэсгийг байгуулсны хамт Засгийн газрын 2004 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээр энэ төрлийн хэрэгт өмгөөлөх туршлагатай, нэр хүнд бүхий олон улсын хуулийн компанийг хөлслөн ажиллуулахаар үүрэг болгосны дагуу хэд хэдэн хуулийн фирм-ийг судалж, АНУ-ын Milbank, Tweed, Hadley and McCloy LLP/цаашид "Милбанк" гэх/-ийг "Хөрөнгө оруулалтын маргааныг

Тайлбар 2.3-г
үзнэ үү.

шийдвэрлэх олон улсын төв"-д Монгол Улсын Засгийн газрыг төлөвлөх боломжтой гэж үзэж сонгосон байна. ДЦС-3-ын гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилттэй холбогдон гарсан уг маргааны талаар аудитын дүгнэлтэд оруулж энэ талаар зөвлөмж гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

3. Зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлт

Сангийн яамны төрийн сангийн газрын өрийн удирдлагын хэлтэс, Түлш, эрчим хүчний яамны тооцоогоор түлш, эрчим хүчний салбарын компаниудын дүнгээр 2005 оны эхний хагас жилийн байдлаар дамжуулан зээлдэх гэрээний графикийн дагуу төлөх ёстой нийт 62.6 тэрбум төгрөгийн зээл, зээлийн хүүгийн төлбөрөөс 29.2 тэрбум төгрөг буюу 46.6 хувийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Түлш, эрчим хүчний салбарын компаниудад дамжуулан зээлдүүлсэн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн өр 2004 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 24.5 тэрбум төгрөг байсан бөгөөд үүний нэлээд хувь нь Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, ДЦС-3, ДЦС-4-т ноогдож байгаа юм.Түлш, эрчим хүчний яам, Сангийн яам хамтран дээрх компаниудтай зээл, хүүгийн төлбөрийн шинэчилсэн график тохирч ажилласнаар 2005 оны эхний хагас жилийн байдлаар нийт 12.7 тэрбум төгрөгийн төлбөр хийхээс 5.4 тэрбум төгрөгийн төлбөр хийгээд байна. Одоо 2005 оны сүүлийн хагас жилийн төлбөрийг барагдуулах арга хэмжээг тус яамнаас зохион байгуулан хэрэгжүүлж байна.

Иймд Аудитын гүйцэтгэлийн тайлангийн төсөлд эрчим хүчний салбар "Төлбөл зохих зээл, хүүгийн төлбөрийн 10 хүрэхгүй хувь л төлөгджээ" гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байгааг холбогдох газруудтай хамтран дахин нягтлан авч үзэх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Цаашид түлш, эрчим хүчний салбарын үр ашгийг сайжруулах зорилгоор гадаад орон, олон улсын байгууллагын зээлийн хөрөнгөөр

ергөтгөл, шинэчлэл хийсэн үйлдвэрүүдийн зээл, хүүгийн төлбөрийн талаар дараахи арга хэмжээ авч, санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь чухал юм. Үүнд:

- Гадаад орон, олон улсын байгууллагаас авсан зээл, хүүгийн төлөх хуваарь, валютын ханшийн хэлбэлзэл, сэлбэг, материал, түлш, шатахууны үнийн өсөлтөөс хамааруулан нүүрс, эрчим хүчний үнийг бодит зардлын төвшинд нь ойртуулан тогтоож мөрдүүлэх чиглэлээр ээлж дараатай чөлөөлөх;
- Дамжуулан зээлдэх гэрээний хүүг гадаад орон, олон улсын байгууллагаас олгосон зээлийн үндсэн хүүгийн төвшинд ойртуулан шинэчлэн тогтоох. Ингэхдээ дамжуулан зээлдэх гэрээний хүүгийн хэмжээг үндсэн зээлийн хүүгийн хэмжээнээс 50.0 хувиас илүүгүй байхаар тогтоох асуудлыг авч үзэж шийдвэрлэх;
- Гадаад орон, олон улсын байгууллагад төлөх үндсэн зээл, хүүгийн төлбөрийг төлбөр хийх үеийн ханшаар тооцож байх, харин үндсэн зээлийн болон дамжуулан зээлдэх гэрээний хүүгийн зөрүүг төлөхөд тогтвортой ханшаар тооцож байх асуудлыг шийдвэрлэх.

Зээл, хүүгийн төлбөртэй холбогдсон дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх нь түлш, эрчим хүчний үйлдвэрүүдэд хөрөнгө, санхүүгийн талаар Засгийн газраас үзүүлэх бодлогын чанартай томоохон дэмжлэг болохын дээр үйлдвэр хооронд болон санхүүгийн байгууллага хооронд үүссэн өр, авлагын сүлжээг тайлах, салбарын санхүүгийн чадавхийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлэх болно гэж үзэж байна.

4. Төслийн зээлийг хэрэгжүүлсэн байгууллагын удирдлагын чадвар, харууллага.

Дэлхийн Банкны Эрчим хүчний төсөл нь 2000 оны 11 дүгээр сарын 15-нд хэрэгжиж эхэлсэн. 2001 онд анхны гадаадын тендерүүд ба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх гуалин, төмөр бетон хөл нийлүүлэх тендерүүдийг зарлаж, 2002 онд гуалин, төмөр бетон хөлийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад нийлүүлсэн. 2003 оноос тендерээр нийлүүлэгдэх гадаад бараа материалууд бууж эхэлсэн боловч тухайн үед

Тайлбар 2.4-г үзнэ үү.

төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд гадаад болон дотоод материалыг хадгалах агуулахыг бүрэн шийдээгүй байсан ба улсын төсвийн 2002, 2003 оны хөрөнгө оруулалтад төслийн БУА-ыг санхүүжүүлэхэд нэг ч төгрөг тусгагдаагүй болно. 2004 онд төслийн БУА-д 600 гаруй сая төгрөг тусгасан боловч энэ нь УБЦТС ХК-ийн 4 салбар ба аймагуудын БУА-ын 30% хүрэхгүй хувийн санхүүжилттэй тэнцэж байв. Яам дундын тендерийн хорооны шийдвэр байнга цаг алдаж гардаг бөгөөд гэрээ байгуулахад хугацаа их алддаг тул дээр дурьдсан шалтгаануудаас болж төслөөр нийлүүлсэн асар их хэмжээний бараа материалыг 2 жил орчим хугацаанд хадгалах зайлшгүй байдал үүссэн байна. Үүнд 100 гаруй сая төгрөгний хадгалалтын хөлс гарсан ба өнөөдөр ч хадгалалтын хөлс гарсаар байна. 2005 оны байдлаар УБЦТС ХК-ний хамгийн том болох 4 салбарын БУА-ын санхүүжилтэд дөнгөж 20 орчим хувийн санхүүжилт олгож байгаагаас болж дахин 1 жил орчим хугацаагаар бараа материалуудыг хадгалах шаардлагатай болж байна. Дээрх нөхцөл шалтгаанаар хадгалалтын зардал гарсаар байна.

5. Төслийн зээлийн гэрээний биелэлт, түүнд таавьж буй хяналт

“Тайширын усан цахилгаан станц барих” төслийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан зарим тогтоол, шийдвэрийн биелэлт хангалтгүй байгаа талаар тайлангийн төсөлд заасныг анхааралдаа авч байна. Засгийн газрын 2005 оны 33 дугаар тогтоолоор Дөргөн, Тайширын усан цахилгаан станцыг барьж байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, барилгын материал, машин механизмыг тасралтгүй нийлүүлэх шаардлагыг харгалзан 2008 он хүртэлх хугацаанд “Булган”, “Бургастайн” хилийн боомтуудыг байнгын ажиллагаатай болгох асуудлыг шийдвэрлэхийг Гадаад Хэргийн Яам, Түлш, эрчим хүчний яаманд даалгасны дагуу энэ асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Гадаад хэргийн яаманд уламжилсан боловч одоо болтол хариу ирээгүй байна.

“Түгээх сүлжээний алдагдлыг бууруулах” төслийн электрон тоолуур, хэмжих хэрэгслийг баталгаажуулах зорилгоор баталгаажуулалтын үнийг 70 хувь хямдруулах гэрээг Улсын стандарт, хэмжил зүйн үндэсний төвтэй

Тайлбар 2.5-г үзнэ үү.

байгуулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч шийдвэрлэгдэхгүй хүлээгдэж байна.

Аудитын тайлангийн төсөлд заасны дагуу "Эрчим хүчний хөтөлбөр-1" Төслийн удирдах хорооны хяналтын ажлыг идэвхжүүлэх талаар яамны зүгээс анхаарч ажиллах болно. Дээрх төслийн нэмэлт зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлаар дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулах талаар Түлш, эрчим хүчний яам, Диспетчерийн үндэсний төв, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-аас Сангийн яаманд тавьсны дагуу энэ асуудал шийдвэрлэгдэж гэрээний эцсийн хувилбарыг хүлээж аваад байна.

2004 оны 9 дүгээр сард шинээр байгуулагдсан Түлш, эрчим хүчний яам тус салбарт гадаад орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн үр, өгөөжийг дээшлүүлэхэд онцгой ач холбогдол өгч байгаа бөгөөд 2005 оны 1 дүгээр сард "Түлш, эрчим хүчний салбарт 1990-ээд оноос хойш гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төслүүд, тэдгээрийн үр дүнгийн тухай" дэлгэрэнгүй мэдээллийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, түүний дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн болно. Түүний зэрэгцээ Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн, холбогдох дүгнэлтийг үндэслэн эрчим хүчний салбар дахь гадаадын зээлийн ашиглалтын өгөөжийг дээшлүүлэх, зээл, хүүгийн буцаан төлөлтийг улам сайжруулах чиглэлээр шаардагдах арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.

ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

2005-XI-01

<p>Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар</p>	<p>Тайлбар 1.1</p> <p>Саналын 1, 2, 3 дугаар заалтуудад зээлийн эргэн төлөлт сайжрахгүй байгаа, тендерт шалгарсан гүйцэтгэгч байгууллагын буруугаас ажлын гологдол гарч хугацаа алдаж байгаа, салбарын яамдын хяналт сул, тооцоо судалгаа хангалтгүй хийгддэг талаар аудитын тайланд тодорхой тусгаж өгөхийг хүсчээ. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн “Аудитын дүн” гэсэн хэсэгт дээрхи асуудлуудыг тусгасан тул нэмж оруулах шаардлагагүй гэж үзсэн болно.</p> <p>Тайлбар 1.2</p> <p>Саналын 4 дүгээр заалтад “Зарим төсөл, хөтөлбөрүүдэд заасан Монголын талын гаргах санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын орлогоос тодорхой хувиар гаргуулж байх талаар аудитын тайланд тусгаж, асуудал тавих нь зүйтэй” гэжээ. Энэ талаар эрх зүйн ямар нэг зохицуулалт байхгүй тул тайланд тусгах боломжгүй байна.</p>
<p>Түлш, эрчим хүчний яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар</p>	<p>Тайлбар 1.3</p> <p>Саналын 5 дугаар заалтад зээлийн буцаан төлөлтийн талаар 2000 оноос хойш хийж байгаа ажлыг аудитын тайлангийн дүгнэлтэд тусгаж өгөхийг хүсчээ. Сангийн яамнаас дамжуулан зээлдүүлэх гэрээ нөхөн байгуулах, Улсын төвлөрсөн төсвийн дансанд тусгах, өрийн үлдэгдлийн хэмжээг тогтоох, зээлийн буцаан төлөлтийг сайжруулах талаар зохих арга хэмжээ авч байгаа тул аудитын тайлангийн дүн гэсэн хэсэгт оруулсан болно.</p> <p>Тайлбар 2.1</p> <p>Саналын 1 дүгээр заалтад гүйцэтгэлийн аудитын эхний зорилт болох тендерийн шалгаруулалттай холбогдсон аудитын дүнгийн талаар цаашид анхааралдаа авч хяналт тавьж ажиллах талаар тайлбар өгсөн байна. Тайлангийн төсөлд оруулах ямар нэг санал ирүүлээгүй болно.</p> <p>Тайлбар 2.2</p> <p>Саналын 2 дугаар заалтад аудитын 2 дахь зорилтын дүнтэй холбогдсон тухайн салбарт гарч байгаа санхүүгийн бэрхшээл, тайлбар, аудитын явцад илэрсэн зарим зөрчлийг арилгасан тухай, цаашид хийж гүйцэтгэх ажил, аудитын тайлангийн төслийн дүнг дэмжиж байгаа талаар тэмдэглэсэн байна. Түүнчлэн Даланзадгадын ДЦС-ыг барих төслийн үр дүн, ДЦС-3-ын төслийн зээлийн хэрэгжилттэй холбогдон гарсан маргааны талаар аудитын дүгнэлтэд оруулж зөвлөмж гаргаж өгөхийг хүсчээ. Эдгээр асуудал аудитын хамрах хүрээнд ороогүй тул дүгнэлт өгөх боломжгүй юм.</p> <p>Тайлбар 2.3</p>

Саналын 3 дугаар заалтад “СЯ-ны Өрийн удирдлагын хэлтэс, ТЭХЯ-ны тооцоогоор түлш, эрчим хүчний компаниуд дүнгээр 2005 оны эхний хагас жилийн байдлаар дамжуулан зээлдэх гэрээний графикийн дагуу төлөх ёстой нийт 62,6 тэрбум төгрөгийн зээл, зээлийн хүүгийн төлбөрөөс 29,2 тэрбум төгрөг буюу 46,6 хувийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. ...Иймд Аудитын гүйцэтгэлийн тайлангийн төсөлд эрчим хүчний салбар төлбөл зохих зээл, хүүгийн төлбөрийн 10 хүрэхгүй хувь л төлөгджээ” гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байгааг холбогдох газруудтай хамтран дахин нягтлан авч үзэх нь зүйтэй гэсэн саналтай байна.” гэжээ.

Гүйцэтгэлийн аудитын дүгнэлтийг хийхдээ СЯ-ны Өрийн удирдлагын хэлтсээс 2005 оны эхний хагас жилийн байдлаар ҮАГ-т гаргаж өгсөн тооцоо, судалгааг үндэслэн гаргасан болно. Харин дээрхи тооцоо нь 1991-2005 оны эхний хагас жилийн байдлаар аудит хийгдэж дууссаны дараа гаргаж ирүүлсэн тооцоо юм. СЯ-ны Өрийн удирдлагын хэлтсээс 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 5-9б/4103 албан тоотоор ирүүлсэн зээл төлөлтийг харуулсан хүснэгтийг дахин нягтлан үзэж баталгаажуулж зээл, зээлийн хүүгийн төлөлт 1991-2005 оны эхний хагас жилийн байдлаар 47,4 хувьтай байгаа тул гүйцэтгэлийн аудитын тайланд өөрчлөлт орууллаа.

Тайлбар 2.4

Саналын 4 дүгээр заалтад төсөлд тусгагдаагүй хадгалалтын зардал гарч байгаа шалтгааныг тайлбарлаж тэмдэглэсэн тул тайланд өөрчлөлт ороогүй болно.

Тайлбар 2.5

Саналын 5 дугаар заалтад төслийн зээлийн гэрээний биелэлт, түүнд тавьж буй хяналтын талаар хийж байгаа ажил, цаашид анхаарч хэрэгжүүлэх ажлын талаар товч тайлбар ирүүлсэн байна.

Зөвлөмж

Гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараахь албан тушаалтанд дор дурдсан зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Сангийн сайд Н.Алтанхуягт:

- Дотоодын байгууллагад дамжуулан олгох зээлийн төлөх хугацаа, хүүгийн хувь хэмжээг оновчтой тогтоох, гэрээ байгуулаагүй байгууллагатай гэрээ нөхөн байгуулж, зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлтийг сайжруулах
- Монголын талын оруулах санхүүжилтийг хугацаанд нь хийж төслийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах
- Тендерийн шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллах

2. Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүүд:

- Төслийн Удирдах хорооны ажлыг тогтмолжуулж, эрчим хүчний салбар дахь гадаадын зээлийн ашиглалт, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлтийг сайжруулах арга хэмжээ авах
- “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-д хэрэгжсэн төслийн хүрээнд баригдсан 856.2 сая иений өртөг бүхий цахилгаан эрчим хүчний байгууламжийн өмчлөлийн асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх

3. Төрийн өмчийн хорооны даргад:

- Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хувьчлахдаа Засгийн газрын шугамаар авч ашигласан зээлийн хөрөнгийн асуудлыг хамт авч үзэн шийдвэрлэж байх
- Зээлийн өрийг нь тооцолгүй хувьчилсан аж ахуйн нэгжүүдээр зээлийн өрийг нь төлүүлэх арга хэмжээ авах

Аудитын тайлангийн талаар асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факс, mnaoadmin@magicnet.mn и-мэйл хаягаар харилцана уу.

Тэргүүлэх аудитор О.Мэндбаяр

Эрчим хүчний салбарт олгосон гадаад зээлийн
ашиглалт, буцаан төлөлтөд хийсэн аудитын
тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Эрчим хүчний салбарт Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, хандивлагч орны зээлээр хэрэгжсэн төслүүдийн тендерийн шалгаруулалт, эрчим хүчний салбарын гадаад зээлийн буцаан төлөлтөд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитын тайланг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Сангийн сайд, Түлш, эрчим хүчний сайд нарт танилцуулсугай.

Гурав. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2006 оны 6 дугаар сард Үндэсний аудитын газарт танилцуулахыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүү нарт зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

Хуулбар үнэн:

ТАМГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

С.ЛХАГВАСҮРЭН